



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дөргөн сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/105/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар  
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn  
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн  
Утас:70432545  
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn  
Эл би альфа экспэйншин аудит ХХК  
Аудитор: Б.Бадамцэцэг  
Цахим хаяг: auditbadamaa@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>Асуудлыг онцолсон хэсэг</b> .....	3
Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаартай чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 3.0 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй байна. ....	3
<b>Аудитын гол асуудал</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
<b>3.5.1 Төсвийн төлөвлөлт</b> .....	12
<b>3.5.2 Төсвийн гүйцэтгэл</b> .....	12
<b>3.5.3 Нэмэлт төсөв</b> .....	13
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	13
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	13
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	13
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	14
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	14
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	14
<b>4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн</b> .....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	15
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ӨХЗ	Өмч хамгаалах зөвлөл



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

ДӨРГӨН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Б.УДВАЛ ТАНАА

2023.02.17 № 252  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Дөргөн сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Ховд аймгийн Дөргөн сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Аудитын онцолсон хэсэг

Тус сургууль нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүждэг байсан бол тайлант оны эхний 4 сард тогтмол зардлын санхүүжилтийг орон нутгаас, сүүлийн саруудын санхүүжилтийг улсын төсвөөс авсан онцлогтой байна.

Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаартай чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 3.0 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй байна.

### Аудитын гол асуудал

Засгийн Газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын нормативын хэмжээг шинэчлэн тогтоосон. Боловсрол Шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаалаар сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэгдэл урамшууллыг олгосон байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06 -ны өдрийн А/192 дугаар тушаалын хавсралтын дагуу илүү цагийн хөлсийг олгохдоо дундаж цалин хөлс тооцох журмыг баримтлаагүй байна.

### Бусад асуудлын хэсэг

021020796

Тус цэцэрлэг нь 2022 онд нийт 175 хүүхэд сургах хүчин чадалтайгаас гүйцэтгэлээр 175 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамруулж биелэлт 100 хувьтай байна.

Тус байгууллага нь тайлант онд 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 94 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>62,711,938.98</b>	<b>74,261,714.01</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	3,034,949.91
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	-	3,034,949.91
31211	Төрийн сангийн харилцах	-	3,034,949.91
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,801,477.18	1,168,113.30
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,801,477.18	1,168,113.30
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	60,910,461.80	70,058,650.80
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	10,812,584.30	11,984,784.30
35110	Тусгай зориулалттай материал	10,112,584.30	11,284,784.30
35130	Эм боох материал	700,000.00	700,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	50,097,877.50	58,073,866.50
35410	Бичиг хэргийн материал	199,000.00	199,000.00
35420	Аж ахуйн материал	21,396,075.00	24,475,575.00
35460	Хүнсний материал	2,627,346.00	7,523,835.00
35470	Бусад хангамжийн материал	25,875,456.50	25,875,456.50
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>494,212,731.69</b>	<b>472,712,940.77</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	494,212,731.69	472,712,940.77
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	480,005,631.85	458,620,091.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	491,770,647.44	491,770,647.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	(49,326,739.07)	(67,107,044.51)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,947,032.00	39,947,032.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,717,716.03)	(33,119,021.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	68,702,540.48	68,702,540.48
39208	Хуримтлагдсан элэгдэл	(43,270,132.97)	(45,994,062.57)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	900,000.00	900,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө		3,520,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	14,207,099.84	14,092,849.76
39301	Програм хангамж	732,000.00	732,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(503,500.16)	(617,750.24)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,978,600.00	13,978,600.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>556,924,670.67</b>	<b>546,974,654.78</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>556,924,670.67</b>	<b>546,974,654.78</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	556,924,670.67	546,974,654.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	542,229,470.00	542,229,470.00
51101	Өмч: - төрийн	542,229,470.00	542,229,470.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(19,354,166.04)	(29,304,181.93)
51210	Өмнөх үеийн үр дүн	(19,354,166.04)	(19,354,166.04)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(9,950,015.89)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	34,049,366.71	34,049,366.71
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>556,924,670.67</b>	<b>546,974,654.78</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан/Төгрөгөөр/**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>443,467,104.00</b>	<b>502,797,650.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>636,100.00</b>	<b>4,642,200.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	636,100.00	4,642,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	636,100.00	4,642,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	636,100.00	4,642,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>442,831,004.00</b>	<b>498,155,450.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>409,426,700.00</b>	<b>448,615,300.00</b>
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	409,426,700.00	448,615,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,205,037.00</b>	<b>180,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө.түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	326,037.00	180,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	410,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,469,000.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>24,199,267.00</b>	<b>49,360,150.00</b>
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	24,199,267.00	49,360,150.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>465,588,992.79</b>	<b>512,747,665.89</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>465,588,992.79</b>	<b>512,747,665.89</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>424,734,007.21</b>	<b>512,747,665.89</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>303,577,842.93</b>	<b>343,220,319.67</b>
210101	Үндсэн цалин	303,577,842.93	343,220,319.67
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>38,487,488.34</b>	<b>42,811,741.30</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,964,125.21	29,115,901.70
210202	Тэтгэмжийн даатгал	3,036,152.91	3,432,641.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,428,922.33	2,746,113.11
210204	Ажилгүйдлийн даатгал	550,753.45	676,750.49
210205	Эрүүл мэндийн даатгал	5,507,534.44	6,840,334.62
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>22,625,267.00</b>	<b>30,393,879.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,425,267.00	2,979,379.00
210302	Түлш, халаалт	20,200,000.00	27,414,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,216,837.00</b>	<b>-</b>
210401	Бичиг хэрэг	168,000.00	
210402	Тээвэр, шатахуун	2,742,337.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	249,600.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	791,500.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	265,400.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>25,851,274.00</b>	<b>56,514,854.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,830,200.00	
210502	Хоол, хүнс	21,405,774.00	56,514,854.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	615,300.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>189,000.00</b>	<b>-</b>
210604	Урсгал засвар	189,000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>447,900.00</b>	<b>-</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,900.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>29,338,397.94</b>	<b>39,806,871.92</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	14,787,081.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,821,200.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,517,197.94	25,019,790.92
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>40,854,985.58</b>	<b>-</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8,469,000.00</b>	<b>-</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,469,000.00	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,385,985.58	
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(22,121,888.79)</b>	<b>(9,950,015.89)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(22,121,888.79)</b>	<b>(9,950,015.89)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>442,831,004.00</b>	<b>498,155,450.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>442,831,004.00</b>	<b>498,155,450.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>409,426,700.00</b>	<b>448,615,300.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	409,426,700.00	448,615,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,205,037.00</b>	<b>180,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	326,037.00	180,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	410,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,469,000.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>24,199,267.00</b>	<b>49,360,150.00</b>
132003	Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/	24,199,267.00	49,360,150.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>442,831,004.00</b>	<b>495,120,500.09</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>442,831,004.00</b>	<b>495,120,500.09</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>401,976,018.42</b>	<b>495,120,500.09</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>304,592,214.42</b>	<b>342,157,334.09</b>
210101	Үндсэн цалин	181,074,700.00	243,948,904.03
210102	Нэмэгдэл	103,763,914.42	85,321,507.48
210104	Урамшуулал	19,753,600.00	12,886,922.58
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>39,340,000.00</b>	<b>44,010,600.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	27,683,700.00	28,312,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,914,100.00	3,487,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,331,300.00	2,849,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	582,800.00	210,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,828,100.00	9,149,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>24,039,867.00</b>	<b>31,579,879.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,392,867.00	3,466,379.00
210302	Түлш, халаалт	20,200,000.00	27,414,500.00

210303	Цэвэр, бохир ус	447,000.00	699,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,704,137.00</b>	<b>-</b>
210401	Бичиг хэрэг	121,500.00	
210402	Тээвэр, шатахуун	1,456,100.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	99,800.00	
210404	Ном, хэвлэл	69,400.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	736,037.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	221,300.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>22,759,700.00</b>	<b>62,746,737.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,073,200.00	
210502	Хоол, хүнс	18,993,200.00	62,746,737.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	693,300.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>159,400.00</b>	<b>158,000.00</b>
210604	Урсгал засвар	159,400.00	158,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>125,900.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	125,900.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,655,600.00</b>	<b>1,110,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,223,600.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,110,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,599,200.00</b>	<b>13,357,950.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		10,357,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,599,200.00	3,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>40,854,985.58</b>	<b>-</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8,469,000.00</b>	<b>-</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	8,469,000.00	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,385,985.58	
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>≡</b>	<b><u>3,034,949.91</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>3,034,949.91</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>3,034,949.91</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	542,229,470.00	34,049,366.71	(19,354,166.04)	556,924,670.67
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	542,229,470.00	34,049,366.71	(19,354,166.04)	556,924,670.67
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	542,229,470.00	34,049,366.71	(19,354,166.04)	556,924,670.67
D08	Тайлант үеийн үр дүн			(9,950,015.89)	(9,950,015.89)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	542,229,470.00	34,049,366.71	(27,716,337.93)	548,562,498.78

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Тайлант оны	
		төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	499742800.00	495120500.09
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	499742800.00	495120500.09
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	499742800.00	495120500.09
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	343383200.00	342157334.09
210101	Үндсэн цалин	282933600.00	243948904.03
210102	Нэмэгдэл	51952000.00	85069984.60
210104	Урамшуулал	8497600.00	13138445.46
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	44010600.00	44010600.00
210201	Тэтгэврийн даатгал	29926700.00	28312700.00
210202	Тэтгэмжийн даатгал	3487800.00	3487800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2849900.00	2849900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	704500.00	2318500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7041700.00	7041700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	31940600.00	31579879.00
210301	Гэрэл, цахилгаан	3536400.00	3466379.00
210302	Түлш, халаалт	27561600.00	27414500.00
210303	Цэвэр, бохир ус	842600.00	699000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	65,725,800.00	62,746,737.00
210502	Хоол, хүнс	65,725,800.00	62,746,737.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	159,400.00	158,000.00
210604	Урсгал засвар	159,400.00	158,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	1,110,000.00	1,110,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,110,000.00	1,110,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	13,413,200.00	13,357,950.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,413,200.00	10,357,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	3,000,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	497,975,450.00	497,975,450.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	448,615,300.00	448,615,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	448,615,300.00	448,615,300.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	49,360,150.00	49,360,150.00
132001	Орон нутгийн төсвөөс	49,360,150.00	49,360,150.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>3,034,949.91</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	25.00	25.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	176.00	176.00
<b>631</b>	<b>СӨБ</b>	176.00	176.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	176.00	176.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>24.00</b>	<b>24.00</b>
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	17.00	17.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дөргөн сумын цэцэрлэг нь "хамт олны хандлага ёс зүйг сайжруулах, олон нийтийн оролцоонд суурилан хүүхэд нэг бүрийн эх хэлний чадвар, хөгжил, төлөвшлийн чанарт ахиц гаргах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, сургалтын орчинг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, өөртөө үнэлгээ хийх, багш, хүүхдийг хөгжүүлэх, чиглүүлэх, эцэг эх, хүүхдийнхээ хөгжил төлөвшлийг дэмжих, багштай холбоо тогтоох, хамтран ажиллах" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлжээ.

Дээрх зорилго, зорилтын хүрээнд БСШУС, аймгийн БСУГ-аас дэвшүүлсэн зорилго зорилтыг ханган сургуулийн өмнөх боловсролын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, орон нутгийн боловсролын төлөвлөлтийг боловсруулан хэрэгжүүлж боловсролын үйлчилгээний хүртээмж, олон нийтийн бүтээлч оролцоог нэмэгдүүлэхэд үйл ажиллагаатайгаа уялдуулахад чиглүүлж ажилласан байна

БСШУ-ны сайдын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/439 тоот тушаалаар Дөргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийг 25 орон тоотой байхаар баталсан байна. Дөргөн сумын цэцэрлэг нь эрхлэгч 1, арга зүйч 1, багш 8, туслах багш 8, нярав 1, тогооч 1, тогоочийн туслах 1, сав угаагч 1, үйлчлэгч 2, манаач 1 албан хаагчидтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Тус цэцэрлэгийн 5 настай хүүхдийг СӨБ-д бүрэн хамруулах ажлын хүрээнд өнгөрсөн хичээлийн жил 36 хүүхдийг танхимаар болон хувилбараар бүрэн хамруулан 1-р ангид шилжүүлэн өгсөн.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллага нь үйл ажиллагаандаа Бага дунд боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- "Хувьсах зардлын дундаж норматив тогтоох тухай" Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол;
- "Хичээл, сургалтын үйл ажиллагаа, Багшийн тасралтгүй хөгжил, цахим хэрэглээ, тоног төхөөрөмж нөхөн хангалт батлах тухай" Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал;
- "Төрийн болон орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар үр дүн үнэлж, үр дүнгийн урамшуулал олгох журам" Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаал тус тус шинэчлэгдэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын ажилтан томилсон, дотоод хяналтын баг өдөр тутмын үйл ажиллагаандаа хяналт хэрэгжүүлж ажилласан байна. Иймд дотоод хяналтын хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.

Тайлант онд БШУЯ-ны дотоод аудитын алба болон аймгийн ЗДТГ-ын Санхүү, дотоод аудитын албанаас тус сургуулийн 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дөргөн сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дөргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9.9 сая төгрөгөөр буюу 1.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	3,034.9	3,034.9
Авлага	1,801.5	1,168.1	(633.4)
Бараа материал	60,910.5	70,058.8	9,148.3
Үндсэн хөрөнгө	494,212.7	472,712.9	(21,499.8)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>556,924.7</b>	<b>546,974.7</b>	<b>(9,950.0)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	556,924.7	546,974.7	(9,950.0)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>556,924.7</b>	<b>546,974.7</b>	<b>(9,950.0)</b>

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25 өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 3.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ✓ Бараа материалын үлдэгдэл 9,1 сая төгрөгийн хүнс, аж ахуйн материал худалдан авалтыг хийж бараа материалын үлдэгдэл өссөн байна.
- ✓ Авлага 0,6 сая төгрөгөөр буурсан нь НДШ-ийн төлөлттэй холбоотой байна
- ✓ Үндсэн хөрөнгийн дансны бууралтад элэгдлийн зардал нөлөөлсөн байна.

Дээрх хүснэгтээс харахад Дөргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9950.0 мянган төгрөгөөр буурсны материаллаг нөлөө нь авлага буурсан, бараа материал нөөцөлж үлдэгдэл өссөн, төрийн сангийн харилцах данстай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 448.6 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 49.4 сая төгрөг нийт 497.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвөөс 448.6 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 49.4 сая төгрөг нийт 497.9 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг тодотгоогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 448.6 сая төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 49.4 сая төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 448.6 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 49.4 сая төгрөг нийт 497.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 494.9 сая төгрөг буюу 95.1 хувьтай байгаа нь төсвийн харилцахын үлдэгдэл 3.0 сая төгрөг байгаатай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Сургуулийн өмнөх боловсрол -71801				
1	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал-80111	31,737.8	31,737.8	-	100
2	Нийтлэг үйлчилгээ-80112	17,622.3	17,622.3	-	100
3	Эрүүл мэндийг дэмжих-81605	1,500.0	1,500.0	-	100
4	Цэцэрлэгийн хүүхдийн хоол-81807	65,725.8	62,746.7	2,979.1	95
5	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин-81816	1,953.2	1,898.0	55.2	97
6	Боловсролын байгууллагын багш-81823	1,500.0	1,500.0	-	100
7	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөр-81834	333,481.8	333,481.8	-	100
8	Сургалтын хэвийн үйл ажиллагаа-81835	44,454.5	44,454.5	-	100
	ДҮН	497,975.4	494,941.1	3,034.3	99

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт төсөвтэй холбоотой нэмэлт дансаар ямар нэгэн гүйлгээ гараагүй болно.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дөргөн сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн цалин хөлс илүү цагийн мөнгө олголттой холбоотой зөвлөмж тусгасан.

Аудитыг Эл би альфа экспэйншин аудит ХХК-ны аудитор Б.Бадамцэцэг 2023 оны 01 дугаар сарын 10-наас 01 дугаар сарын 15-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01 албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 465.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5.6 сая төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Дөргөн сумын Хүүхдийн цэцэрлэг нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцастай холбоотой тус газраас зардал гараагүй.

9 дүгээр зүйлд заасан албан томилолтын хувьд тус байгууллага нь 2022 онд томилолтын зардлыг олгоогүй байна.

11 дүгээр зүйлд заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн хувьд БШУС-ын 2022 оны 11 дүгээр сарын 29-ны А/500 тоот тушаалын хавсралт 4,1, 4.2-т заасны дагуу нэмэлт урамшууллаар 7.9 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон байна.

12 дугаар зүйлд заасан бусад хангамжийн хувьд холбоотой зардал гараагүй байна.

13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалт, 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардал гараагүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 143 мэдээллээс хугацаандаа оруулсан 142 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 1 байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар өгөгдсөн 0.8 сая төгрөгийн 1 акт, дотоод хяналт хэрэгжүүлээгүй, бараа материалын тайлан гаргалт хангалтгүй гэсэн 2 зөвлөмж өгөгдсныг бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	774.8	1	774.8	100
Зөвлөмж	2	-	2	-	0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>774.8</b>	<b>3</b>	<b>774.8</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал нь багш нарын амралтын цалинг, цэцэрлэгийн хүүхдийн хоолыг хянах нь зүйтэй гэж үзлээ.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6.0 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс санхүүгийн тайланд алдаатай илэрхийлсэн 3.4 сая төгрөгийн гүйлгээг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийж зөрчлийг арилгуулсан.

Үүнд:

- ✓ **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**
- ✓ Мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилтийг 0,2 сая төгрөгөөр илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтлана", 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 13.1-д "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв, гаргах үндэслэл болно"
- ✓ Хуримтлагдсан үр дүнг буруу илэрхийлсэн 1.6 сая төгрөгийг залруулсан нь Сангийн сайдын 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.76-д "орлого, зарлагын нэгдсэн зөрүүгээр тайлангийн үеийн үр дүнг тодорхойлно"
- ✓ Хүнсний материалын үлдэгдлийг 1,6 сая төгрөгөөр илүү тайлагнасаныг залруулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", нийт 3.4 сая төгрөгийг залруулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Аудитаар нийт 6.0 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 1.0 сая төгрөгийн зөвлөмж, 3,4 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад тухайн байгууллагын 2023 оны 02-р сарын 14 тоот албан бичгээр залрууллаа.

#### 5.2 Төлбөрийн акт

10,11-р сард ээлжийн амралтын хугацаанд үр дүнгийн урамшуулал бодож 0.4 сая төгрөгийн цалин илүү олгосон, 0.02 сая төгрөгийн утасны нэгж худалдан авсан, ЕБС-аас үр дүнгийн урамшуулалт цалин авсан боловч цэцэрлэгээс давхардуулан 0.4 сая төгрөг илүү олгосон, ҮЭ-ийн татварыг 0.01 сая төгрөг илүү шилжүүлсэн, хүүхдийн хоолны норматив хэтрүүлэн олгосон 0.23 сая, шатахууны үнэ шилжүүлж И баримт авсан боловч өөр материал худалдан авсан 0.5 сая төгрөгийн нийт 1,6 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

### 5.3 Зөвлөмж

#### 5.3.1 Шатахууны зарцуулалттай холбоотой

**Илрүүлэлт:** Шатахууны тооцоо бодоогүй, тайлан гаргаагүй, замын хуудас бичээгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, шууд зарлага гаргасан, 1.0 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтлана", 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 13.1-д "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв, гаргах үндэслэл болно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" 20-р зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

**Өгсөн зөвлөмж:** Анхан шатны баримтыг бүрдүүлж, тайлан гаргаж, тооцоо бодож хэвших, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн гүйлгээний тайланд болон үр дүнгийн тайланд орлого санхүүжилтийг илүү тайлагнасан	1.0	0.2	-	-	1.0	0.2	1.0	0.2	-	-	-	-
Үр дүнгийн тайланд тайлант оны үр дүнг буруу илэрхийлсэн	1.0	1.6			1.0	1.6	1.0	1.6				
Бараа материалын тайлангийн эцсийн үлдэгдлийг буруу тайлагнасан	1.0	1.6			1.0	1.6	1.0	1.6				

Шатахууны тооцоо бодоогүй, тайлан гаргаагүй, замын хуудас бичээгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, шууд зарлага гаргасан	1.0	1.0						1.0	1.0	1.0	1.0	
<b>Дүн</b>	<b>4.0</b>	<b>4.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3.0</b>	<b>3.4</b>	<b>3.0</b>	<b>3.4</b>	<b>1.0</b>	<b>1.0</b>	<b>1.0</b>	<b>1.0</b>

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шатахууны тооцоо бодоогүй, тайлан гаргаагүй, замын хуудас бичээгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, шууд зарлага гаргасан	1	1.0					1	1.0
10,11-р сард ээлжийн амралтын хугацаанд үр дүнгийн урамшуулал бодож олгосон 438.6 мянган төгрөгийн цалин илүү олгосон, 18.0 мянган төгрөгийн утасны нэгж худалдан авсан, ЕБС-аас үр дүнгийн урамшуулалт цалин авсан боловч цэцэрлэгээс давхардуулан 388.5 мянган төгрөг илүү олгосон, ҮЭ-ийн татварыг 10.0 мянган төгрөг илүү шилжүүлсэн, хүүхдийн хоолны норматив хэтрүүлэн олгосон 231.1, шатахууны үнэ шилжүүлж И баримт авсан боловч өөр бараа материал авсан 500.0 мянган төгрөгийн нийт 1553.1 мянган төгрөгийн төлбөр зөрчил илэрлээ.	1	1.6	1	1.6				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>2.6</b>	<b>1</b>	<b>1.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>1.00</b>

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:**

**Х.БОЛДБААТАР**

**АУДИТЫН МЕНЕЖЕР:**

**А.ЦЭЦЭГСҮРЭН**

**ТАЙЛАНГ БИЧСЭН:**

**ЭЛ БИ АЛЬФА ЭКСПЭИНШИН АУДИТ ХХК**

**АУДИТОР:**

**Б.БАДАМЦЭЦЭГ**



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 24/А-2160424

Ховд

ХОА-2022/104/НА/-СТА-ТШЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дөргөн сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланд аудит хийхэд ажилчдад ээлжийн амралтын хугацаанд ур чадвар олгосон, ур чадварын нэмэгдлийг давхардуулан олгосон, шатахууны үнэ шилжүүлж И баримт авсан боловч өөр материал худалдан авсан, төсвийн хөрөнгөөр нэгж худалдан авсан, хүүхдийн хоолны нормативыг хэтрүүлэн зарцуулсан нийт 1596231 төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах заалтуудтай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээр дурдсантай холбоотой 1596231 /Нэг сая таван зуун ерэн зургаан мянга хоёр зуун гучин нэгэн төгрөг/ -ийг Төрийн сан банкин дахь бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2022 оны 04 дүгээр сарын 25-ны дотор төвлөрүүлэх.
2. Тогтоосон төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч төлбөрийн актын биелэлтийг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дөргөн сумын Цэцэрлэгийн эрхлэгч Б.Удвал,, нягтлан бодогч О.Балжинням нарт тус тус хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ТЭРГҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

Д.НАРАНТУУЛ